



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "ГТХЗНТ" УТҮГ-ын захирлын 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн сүлжээ ашиглах, цахим хуудас хөтлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ын 6.2 дахь заалтын дараа “6.3.Төвийн компьютер, програм хангамж, сүлжээний дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шаардлагатай төсвийг улсын төсөвт жил бүр суулгах, төсвийн тодотголд тусгах ажлыг мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажилтан захиргааны асуудал хариуцсан нэгжтэй хамтран хэрэгжүүлнэ.” гэж нэмсүгэй.


2. "ГТХЗНТ" УТҮГ-ын захирлын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/45 дугаар тушаалаар баталсан “Ажилтны мэдээллийн технологийн зохистой хэрэглээний журам”-ын “2.2.3.компьютерт вирусээс хамгаалах албан ёсны програм хангамж суулгана,” гэснийг “2.2.3.Нийт ажилтны компьютер, төрөл бүрийн сервер, сүлжээний дэд бүтцэд албан ёсны лицензтэй үйлдлийн систем, оффис хэрэглээний ба вирусээс хамгаалах болон бусад нарийн мэргэжлийн програм хангамж суулгаж ашиглана;” гэж, “3.2.1.компьютер түүний дагалдах тоног төхөөрөмжийг ажлын байрнаас гадагш гаргах, оруулах тохиолдолд захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга, мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажилтнаас зөвшөөрөл авна;” гэснийг “3.2.1.компьютер түүний дагалдах тоног төхөөрөмжийг ажлын байрнаас гадагш гаргах, оруулах тохиолдолд захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга, мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажилтнаас зөвшөөрөл авч лацдаж, үйлдлийн систем, бусад лицензтэй програмын сериал түлхүүрийг бүртгүүлнэ;” тус тус өөрчлөн найруулсугай.

3. Журмын 5.4.6-д "(Default)" гэснийг "(Default)" гэж өөрчилсүгэй.

4. Журмын нэмэлт, өөрчлөлтийг нийт ажилтанд танилцуулахыг мэдээллийн технологийн асуудал хариуцсан ажилтан (Г.Баттөр)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс (Ц.Оюунбат)-т даалгасугай.

ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

000841